



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/288

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, аймагт "108 сая мод" тарьж ургуулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хашаа хамгаалалт сэлбэж, засах ажилд шаардагдах 17,576,000 (арван долоон сая таван зуун далан зургаан мянга) төгрөгийг урсгал зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ